



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/08

Номгон

Орон нутгийн худалдан авалтыг  
дэмжих тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10<sup>1.1</sup> дэх заалт, Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалт, Засгийн газрын 2015 оны “Жагсаалт шинэчлэн батлах тухай” 336 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 16 дугаар тогтоол “Баянхонгор аймгийг үйлдвэржүүлэх нэгдсэн бодлого”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавирусын халдвар гарч эдийн засаг хүндэрсэн, “Баянхонгор аймгийг үйлдвэржүүлэх нэгдсэн бодлого”-ын хүрээнд Баянхонгор аймагт үйлдвэрлэсэн болон үндэсний үйлдвэрийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авч, дотоодын үйлдвэрлэлээ дэмжих, орон нутгийн худалдаа үйлчилгээ эрхлэгчдээс худалдан авалт хийж ажлын байрыг хадгалж үлдэх, шинээр нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулахыг нийт ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагч, үйлдвэрлэгчдэд тус тус уриалсугай.

2.Төсвийн байгууллагын байнгын хэрэгцээтэй бараа, ажил үйлчилгээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1.1-т заасны дагуу ерөнхий гэрээ байгуулж, орон нутгийн үйлдвэрлэл худалдаа үйлчилгээ эрхлэгчдээс авч байхыг бүх шатны Төсвийн шууд захирагч нарт даалгасугай.

3.Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан тохирлын баталгаатай бараа бүтээгдэхүүнийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендерийн баримт бичигт тусгаж, дотоодын худалдан авалтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Орон нутгийн өмчийн газарт үүрэг болгосугай.

4.Орон нутгийн зах зээлд худалдаалж буй бараа бүтээгдэхүүний чанар, хүртээмж өрсөлдөх чадварыг сайжруулахад идэвх санаачлагатай ажиллахыг нийт

1210173

2.

үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэгчдэд бараа бүтээгдэхүүний чанар, стандартад хяналт тавьж хэрэглээний эрэлт нийлүүлэлтийн нийцтэй байдлыг хангуулахад зөвлөн тусалж ажиллахыг Стандарт хэмжил зүйн хэлтэс /М.Хосбаяр/, Мэргэжлийн хяналтын газар /Н.Бямбадорж/, Хүнс, хөдөө аж ахуйн газар /Ж.Баттөр/ нарт тус тус даалгасугай.

5.Дотоодын худалдан авалтын мэдээг нэгтгэж сар бүрийн 25-ны дотор аймгийн Засаг даргад тайлагнаж байхыг Статистикийн хэлтэс /Х.Ганзориг/-т үүрэг болгосугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН